

МАЛЧДЫН ДУНДАХ СУРГАЛТ ЗӨВЛӨГӨӨН, БАЯРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2024 оны 11 дүгээр сарын 22

Хориулт

Сумын малчдын дунд зохион байгуулагдсан сургалт нөлөөллийн үйл ажиллагааг сумын ИТХ-ын дарга Б.Анхбаяр нээж үг хэлж, Хөдөө аж ахуйн тасгийн дарга Л.Ганзориг удирдан явуулж, Засаг дарга Л.Ганаа цаг үеийн ажлаар мэдээлэл хийлээ. Дээрх ажлын хүрээнд “Эрүүл мэндээ хамгаалах энэ иргэн таны үүрэг илтгэлийг Сумын эрүүл мэндийн төвийн дарга, их эмч А.Цэцэгбадам, Цахим орчинд зөв хандлагыг түгээцгээе” илтгэлийг Нийгмийн бодлогын мэргэжилтэн Ц.Отгонсүрэн, “Мод тарих арга технологи” илтгэлийг байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн Ж.Баттунгалаг илтгэн, хэлэлцүүлэг зохион байгуулав. Зөвлөгөөнд нийт 352 малчин оролцов. Зөвлөгөөний дараа Богд сумын уугуул Соёлын тэргүүний ажилтан Г.Баттөмөр, П.Баярмагнай, Б.Баянжаргал ирэн урлагийн тоглолт болов.



Малчдын дунд зохион байгуулагдсан сургалт нөлөөллийн арга хэмжээний хүрээнд хурдан Атан тэмээ, “Шинэ тэмээ”-ний уралдаан, Торомны уралдаан гэсэн 3 төрлийн уралдааныг зохион байгууллаа. Энэ уралдаанд Баянхонгор аймгийн Богд, Баацагаан, Жинст, Шинэжинст, Зэргэлдээ Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан сумын тэмээчид, уяачид



Атан тэмээний уралдаанд нийт 20 тэмээ уралдсанаас Баацагаан сумын уяач Б.Батжаргалын Шар тэмээ түрүүлж, аман хүзүүнд Богд сумын Буянт 5 дугаар багийн уяач Т.Буяндэлгэрийн Шар тэмээ, айргийн 3-т Шинэжинст сумын уяач У.Энхбаатарын улаан, айргийн 4-т Богд сумын Буянт 5 дугаар багийн уяач Т.Энхбаатарын Улаан тэмээ, айргийн 5-т Жинст сумын уяач М.Анхбаярын Халтар тэмээ тус тус хурдаллаа. “Шинэ тэмээн”-ий уралдааныг Хадаг дамжуулах байдлаар үе үеийн тэмээчдын гэр бүл, үр хүүхдүүд ивээн тэтгэж жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг журмын дагуу тэмээчин Р.Лувсанвандан агсны үр хүүхдүүд ивээн тэтгэж оролцож байгаа билээ



“Шинэ тэмээ”-ний уралдаанд зөвхөн Богд сумын тэмээчид, уяачдын урьд өмнө уралдаж байгаагүй тэмээ уралддаг бөгөөд 11 тэмээ уралдсанаас Богд сумын Буянт 5 дугаар багийн уяач Т.Баатархүүгийн Бор тэмээ түрүүлж, аман хүзүүнд Богд сумын Гурван

гол 2 дугаар багийн залуу уяач Л.Сандагсүрэнгийн Хүрэн, айргийн 3-т Богд сумын Алтай 3 дугаар багийн

уяач Б.Ган-Өлзийн Улаан, Айргийн 4-т Богд сумын Буянт 5 дугаар багийн уяач Т.Баатархүүгийн Бор, айргийн 5-т Богд сумын Цэлгэр 4 дүгээр багийн уяач Э.Батпүрэвийн Улаан тэмээ тус тус хурдалсан байна. Тором насны тэмээний уралдаанд хамгийн олон буюу 26 тэмээ уралдаж, Шинэ сумын уяач Т.Дорждэрэмийн Шар тэмээ түрүүлж, Богд сумын Луугар 1 дүгээр багийн уяач Ц.Чимэддагвын Улаан тэмээ аман хүзүүнд, айргийн 3-т Богд сумын Гурван гол 2 дугаар багийн уяач Т.Буянжаргалын Бор тэмээ, айргийн 4-т Шинэжинст сумын уяач Б.Жигжидсүрэнгийн Халзан тэмээ, айргийн 5-т Шинэжинст сумын уяач Б.Чойжилсүрэнгийн Халзан тэмээ тус тус хурдалсан байна.



“Волеболын тэмцээн” эмэгтэй багуудын тоглолтоор эхлэв. Нийт 7 багийн 49 тамирчин оролцон Н.Саруул ахлагчтай “Алтай-1” багийнхан түрүүлж, Б.Оюунбилэг ахлагчтай “Алтай-2” багийнхан 2 дугаар байр, Э.Мөнгөнчимэг ахлагчтай “Гурван гол” 2-р багийнхан 3-р байр эвлэв. Эрэгтэй 6 багийн 42 тамирчин оролцсоноос Б.Бат-Эрдэнэ ахлагчтай “Луугар” баг тэргүүн байр, С.Түвшинсайхан ахлагчтай “Алтай” баг хоёрдугаар байранд, Г.Ган-Эрдэнэ ахлагчтай “Гурван гол” баг гуравдугаар байр эзлэлээ.





Мөн Дартс – тэмцээнд 6 багийн 29 малчин оролцож, “Цэлгэр” баг тэргүүн байр, “Хориулт” баг, “Гурван” гол багууд 2,3 дугаар байранд шалгарч 80,0-180,0 төгрөгийн, Олс таталтын тэмцээнд 6 багийн 60 малчид оролцож, Тэргүүн байрыг “Алтай” баг 2,3 дугаар байрыг “Гурван гол”, “Буянт” багууд эзлэж 120,0-200,0 төгрөгөөр шагнагдлаа.



Энэ өдөр “хөгжөөнт буухиа” тэмцээн болж 6 багийн 60-н тамирчин оролцсноос “Буянт” баг тэргүүлж, “Цэлгэр” баг , “Гурван гол” багууд 2,3 дугаар байрт шалгарлаа



Мөн Уртын дуу, Ардын дуу Шугаман бүжиг, Морь бөх цоллох, Харилцаа дуу, Шагайн наадгай зэрэг урлагийн төрлүүдээр 108 малчин өрсөлдсөн. Ардын дууны төрөлд “Луугар” багийн малчин У.Өлзийхүлэг “Уртын дууны төрөлд “Цэлгэр” багийн малчин Ц.Логио, “Шугаман бүжгийн төрөлд “Луугар багийн Р.Ганцэцэг ахлагчтай бга, Харилцаа дууны төрөлд “Хориулт” багийн Э.Ууганбаяр Т.Мэргэншагай нар, “Шагайн наадгайн” төрөлд “Буянт” багийнхан тус тус “Тэргүүн” байр эзлэв

Малчдын баяр-2024 наадмын урлагийн төрөлд нийт 84 малчид оролцсон. Үүнээс уртын дууны төрөлд:4 дүгээр багийн малчин Н.Логио 1-р байр 5 дугаар багийн малчин П.Тунгалаг 2-р байр 1 дүгээр багийн малчин Ц.Мөнхжаргал 3-р байр Ардын дууны төрөлд:1 дүгээр багийн малчин У.Өлзийхүлэг 1-р байр 4 дүгээр багийн малчин Б.Ганбаяр 2-р байр 3 дугаар багийн малчин Ж.Жаргалсайхан 3-р байр Харилцаа дууны төрөлд:6 дугаар багийн малчин Ж.Ууганбаяр Т.Мэргэншагай1-р байр 3 дугаар багийн малчин Б.Банзрагч Г.Сүнжидмаа 2-р байр 2 дугаар багийн малчин Б.Ууганбаяр С.Хажид 3-р байр

Шугаман бүжигийн төрөлд: 1 дүгээр багийн оролцогчидчид **1-р байр** 4 дүгээр багийн малчид **2-р байр**, 2 дугаар багийн малчид **3-р байр**

Морь бөх цоллоочийн төрөлд: 5 дугаар багийн малчин Б.Энхбаяр 1р байр1 дүгээр багийн малчин Ц.Мөнхжаргал6 дугаар багийн малчин Д.Төмөрсүх



Үйлдвэрлэл эрхлэгчдийн үзэсгэлэн худалдаа 6 төрлөөр зохион байгуулагдан нийт 36 үйлдвэр эрхлэгч төрөл тус бүрд бүтээгдэхүүнээрээ оролцлоо. “Сүү сүүн бүтээгдэхүүн”-ний төрөлд С.Баттогтох тэргүүн байр, Д.Одончимэг 2 дугаар байр, “Мал аж ахуйн бүтээгдэхүүний” төрөлд Н.Саруултуяа тэргүүн байр, А.Чимгээ 2 дугаар байр, “Гар урлалын” төрөлд Богц багц цэгц хоршоо тэргүүн байр, Б.Дөшмөнх 2 дугаар байр, “Талх нарийн боов” үйлдвэрлэл төрөлд Б.Батхүү тэргүүн байр, Ц.Тунгалаг 2 дугаар байр, “Хоол үйлдвэрлэл төрөлд Б.Буянжаргал тэргүүн байр, Ч.Золжаргал 2 дугаар байрт тус тус шалгарлаа.







Үндэсний бөхийн барилдаанд Баянговь сумын харъяат сумын начин Б.Бат-Эрдэнэ түрүүлж, үзүүрт жинст сумын харъяат сумын заан Э.Энхболд, Богд сумын харъяат сумын начин Б.Цэнд-Аюуш, залуу бөх Т.Идэр нар шөвгийн 4-т үлдэв.





Софт волейболын тэмцээн болж, 7 багийн 28 малчид оролцсоноос Б.Баянжаргал ахлагчтай “Гурван гол” баг түрүүлж, Ц.Эрдэнэбат ахлагчтай “Луугар”, Д.Энх-Амгалан ахлагчтай “Алтай” багууд 2,3 дугаар байранд шалгарлаа. Урлагийн төрлүүдэд 1-3 дугаар байр эзэлсэн малчдын “Гала” тоглолт болов.

Багуудын нийлбэр дүнгээр 3 дугаар байрыг Луугар 1-р баг, 2 дугаар Гурван гол 2-р баг, Тэргүүн байранд “Алтай” 3-р баг эзэлсэн байна.

Энэ арга хэмжээ нь малчдад эрүүл мэнд, хүний хөгжлийн талаар сургалт мэдээлэл өгсөн, сум үүсэж хөгжсөний 100 жилийн ойг угтан малчдын урлаг, спортын авьяас чадварыг нээн илрүүлсэн, малчдын хамтын ажиллагааг сайжруулсан, гурван өдрийн үйл ажиллагаа болж өндөрлөлөө